



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/363

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалаар баталсан Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журмын 5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. "Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв"-ийн тусгай зөвшөөрлийн нэр "Чингэлтэй нэгдсэн эмнэлэг" болж өөрчлөгдсөн тул магадлан итгэмжлэлийн батламжийн нэрийг сольж, дугаар болон хүчинтэй хугацааг өмнөх батламжид зааснаар дахин олгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

Ж.ЧИНБҮРЭН

141251841

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
10 дугаар сарын 01-ний өдрийн
А/363 дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Говь-Алтай аймаг, "Машид-Эрдэнэ" ХХК Сэргээн засах төв	280/2025	1 жил	2025.10.01	2026.10.01
2.	Увс аймаг, "Гэгээн булаг" ХХК-ны "Гэгээн булаг" эмнэлэг	281/2025	1 жил	2025.10.01	2026.10.01
3.	Увс аймаг, Хилийн цэргийн 0245-р ангийн Эрүүл мэндийн төв	282/2025	1 жил	2025.10.01	2026.10.01
4.	Төв аймаг, Баянжаргалан сумын эрүүл мэндийн төв	283/2025	3 жил	2025.10.02	2028.10.02
5.	Сүхбаатар аймаг, Мөнххаан сумын эрүүл мэндийн төв	284/2025	3 жил	2025.10.19	2028.10.19
6.	Говь-Алтай аймаг, Төгрөг сумын эрүүл мэндийн төв	285/2025	2 жил	2025.10.01	2027.10.01
7.	Дорноговь аймаг, "Борхон наран" өрхийн эрүүл мэндийн төв	286/2025	2 жил	2025.10.19	2027.10.19